

НЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

- Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлнэ,
- Үнэт цаас гаргагч нь Бонд худалдан борлуулснаас орсон орлогыг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна,
- Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн болон үндсэн төлбөрийг графикин дагуу цаг хугацаанд нь төлнө,
- Үнэт цаас гаргагч нь Бондын үүргийн гүйцэтгэлийг хангахуйц үнийн дүн бүхий, өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө болон борлуулалтын гэрээгээр бондын баталгаа гаргана,
- Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны болон бусад хүчин зүйлээс хамаарч Бондын хүүгийн болон үндсэн төлбөр төлөлтөд гарах эрсдлийг өөрийн хөрөнгөөр хариуцана

БОНД ЭЗЭМШИГЧИД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮҮРЭГ

“Жаст Агро” ХХК нь бондын танилцуулгад заасан зориулалтаар хөрөнгийг зарцуулж байгаа эсэх, хүү тооцсон тооцоолол, төслийн ажлын гүйцэтгэлийн талаар бонд эзэмшигчдэд мэдээллэх үүрэгтэй. Үнэт цаас гаргагч нь тус үүргээ доор дурьдсан байдлаар хэрэгжүүлнэ.

- www.justgroup.mn вэб хуудсаар мэдээлэл тавих /хоёрдогч зах зээлд оролцох сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдэд төсөлтэй холбоотой цаг үеийн мэдээллийг байршуулах/
- Бонд эзэмшигчийн электрон шуудангийн хаягаар гүйцэтгэлийг тайлагнах
- Газар дээрх гүйцэтгэлтэй танилцуулах /бонд эзэмшигч болон хоёрдогч зах зээлд оролцох сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу төслийн гүйцэтгэл, хэрэгжилтийг газар дээр нь биечлэн танилцуулах аялалыг зохион байгуулах/

